

## ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Нийгмийн  
даатгалын үндэсний зөвлөлийн  
тогтоолын төсөл боловсруулсан тухай

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17<sup>1</sup> дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ: 1/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт; 2/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон сурталчилгаа”, 17.2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний зардлын хэмжээ, санхүүжүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж тус тус заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулав.

Нийгмийн даатгалын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 56 057 ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн байна. Эдгээр ажил олгогчдод 1 033 384 албан журмын даатгуулагч хамрагдаж байна.

Эдгээр албан журмын даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гаргана.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 6219 иргэн 27.6 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байгаа бөгөөд үүнээс хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 3511 хүн, түүний зардал 22.6 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 462 хүн, түүний зардал 2.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр

алдсаны тэтгэмж авагч 1090 хүн, түүний зардал 1.3 тэрбум төгрөг байна. 2023 онд зардалд 58.8 тэрбум төгрөг, 2024 онд 59.3 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022 онд 1.1 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 2023 онд 1.6 тэрбум төгрөг, 2024 онд 4.3 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ